Огноо:2025-02-27 № 24/06 Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“МИКРО КРЕДИТ ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид “МИКРО КРЕДИТ ББСБ” ХХК-ийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, тухайн жилийн орлогын, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга, нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бид дүгнэлтээр “МИКРО КРЕДИТ ББСБ” ХХК-ийн 2024 оны 12 сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлангууд нь СТОУС-ын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргаагүй болно.

Бид энэхүү аудитын ажлыг хийж гүйцэтгэж аудитын тайланг бэлтгэсэн болно.

ЗАХИРАЛ Ч.ЭНХЧИМЭГ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ХУРААНГУЙ (төгрөгөөр)

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт		1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		3,017,445,205.91	1,616,711,918.78
1.2 Зээл		20,897,912,950.12	40,637,044,960.13
1.6 Бусад санхүүгийн хөрөнгө		95,401,432.31	95,184,000.00
1.7 Санхүүгийн хөрөнгийн дүн		**24,010,759,588.34**	**42,348,940,878.91**
1.9 Үндсэн хөрөнгө		94,860,867.55	195,141,543.67
1.10 Биет бус хөрөнгө		79,940,349.99	72,476,211.98
1.12 Бусад санхүүгийн бус хөрөнгө		18,704,153.20	58,899,859.05
1.14 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**24,204,264,959.08**	**42,675,458,493.61**
2.8 Санхүүгийн өр төлбөрийн дүн		**18,657,908,980.24**	**35,382,324,101.53**
2.13 Санхүүгийн бус өр төлбөрийн дүн		**218,192,843.57**	**358,685,050.22**
2.14 НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		**18,876,101,823.81**	**35,741,009,151.75**
3.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө		2,700,000,000.00	3,501,000,000.00
3.3 Хуримтлагдсан ашиг, (алдагдал)		2,628,163,135.27	3,433,449,341.86
3.5 НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН		**24,204,264,959.08**	**42,675,458,493.61**

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт		1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1.7.Хүүгийн орлогын дүн		**5,813,872,636.24**	**9,872,901,359.43**
2.6.Хүүгийн зардлын дүн		**2,902,083,633.83**	**5,714,117,571.39**
3.Хүүгийн цэвэр орлого (1.7-2.6)		**2,911,789,002.41**	**4,158,783,788.04**
4.Эрсдэлийн сангийн зардал		287,262,988.98	262,391,477.52
5.Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3-4)		**2,624,526,013.43**	**3,896,392,310.52**
6.Бусад орлого		327,149,976.03	634,876,752.67
7.1 Хүүгийн бус зардал		999,477,550.55	1,414,284,389.20
8.Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)		**1,952,198,438.91**	**3,116,984,673.99**
9.Орлогын татварын зардал		195,219,843.89	311,698,467.40
10.Татварын дараах ашиг, алдагдал (8-9)		**1,756,978,595.02**	**2,805,286,206.59**
12.Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)		1,756,978,595.02	2,805,286,206.59

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1.6 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	24,530,024,000.63	34,958,138,495.67
1.15 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	27,821,441,854.88	45,807,570,244.21
1.16 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	(3,291,417,854.25)	(10,849,431,748.54)
3.5 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	6,941,318,141.10	15,342,307,015.82
3.10 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	2,412,661,247.54	5,704,582,061.91
3.11 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,528,656,893.56	9,637,724,953.91
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,780,206,166.60	3,017,445,205.91
7. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,017,445,205.91	1,616,711,918.78